



191

ML

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2008 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот


ТЭМЦЭЭНД ОРОЛЦУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 189 дүгээр тогтоол, "Биеийн тамир, спортын тухай" хуулийн 18.6, 18.7 дугаар заалт, нийслэлийн Засаг даргын 2007 оны 621, 2008 оны 161 дүгээр захирамжийг тус тус үндэслэн **ТУШААХ НЬ:**

Нэг. Оюутны шигшээ багийн тамирчин Г.Ганнямыг 2008 оны 07 дугаар сарын 01-07-ны өдрүүдэд Катарын Доха хотноо болох Азийн залуучуудын аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд оролцуулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Тэмцээнд оролцоход шаардагдах 2.158.000 /хоёр сая нэг зуун тавин найман мянга/ төгрөгийг Оюутны шигшээ багийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Ж.Цэдэнсодном/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Тэмцээнд амжилттай оролцож, холбогдсон тооцоог ирснээсээ хойш 7 хоногт багтаан санхүүтэй хийж дуусгахыг Оюутны шигшээ багийн тамирчин Г.Ганнямд үүрэг болгосугай.




ДАРГА

Ж.ГАНБОЛД

132 113

НБТСХ-ны даргын 2008 оны 06 дугаар сарын
23-ны өдрийн 76 дугаар тушаалын хавсралт



**ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН
ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Нийт үнэ /төг/
1.	УБ – Бээжин – УБ Бээжин – Доха – Бээжин /1270 ам.долл/ /1 ам.долл - 1160 төг/	1.473.200
2.	Тэмцээний үеийн байр, хоолны зардал: /4 хоног х 110 ам.долл/	510.400
3.	Тэмцээнд оролцогчийн хураамж: /150 ам.долл/	174.000
БҮГД:		2.158.000 /1860 ам.долл/